



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/295

Номгон


Түйн голын ай сав газрын төсөлд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түйн голын ай сав газрын төслийн танилцуулгыг бэлтгэхэд шаардагдах 1.500.000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Түйн голын ай сав газрын төслийн танилцуулга бэлтгэх ажлын зардлын зарцуулалтын тайланг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Насанбат)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН